

6/0.4, 10/0.4 КВ-ЫН ХҮЧНИЙ ТРАНСФОРМАТОРЫН ХУДАЛДАН АВАЛТАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Хүчний трансформаторууд нь дараах олон улсын стандартуудад заасан шаардлагад нийцэж байх ёстой.

Стандартын дугаар	Стандартын нэр
ГОСТ Р 52719-2007	Хүчний трансформатор. Ерөнхий шаардлага
ГОСТ 11920-85	35 кВ хүртэлх хүчдэлийн тосон хөргөлттэй хүчний трансформаторын техникийн шаардлага
ГОСТ 11677-85	Хүчний трансформатор. Ерөнхий шаардлага
IEC 60076	Хүчний трансформатор
IEC 60137	1000 В-оос дээш хүчдэлийн хөндийрүүлэг
IEC 60214	Ачаалал дор хүчдэл тохируулах
IEC 60354	Дүүрэн тостой хүчний трансформаторыг ачаалах зааварчилгаа
IEC 60722	Хүчний трансформатор ба реакторын туршилтын сэлгэн залгалтын импульсын гарын авлага

2. 6-10/0.4 кВ-ын хүчний трансформаторууд нь дээрх олон улсын стандартуудын шаардлагаас гадна УБЦТС ТӨЖК-ийн **ТШТ:ТРР “6-35 кВ хүртэлх ангиллын хүчдэлтэй хүчний бууруулах трансформатор”**-т заасан техникийн шаардлагуудыг хангасан байна.
3. Мөн трансформаторыг суурилуулах орчны нөхцлийн үзүүлэлт нь ТШТ:ЕШН “Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн “24. Орчны нөхцөл”-д заасан шаардлагыг хангасан байх ёстой.
4. Нийлүүлэх бараа материалын **үйлдвэрлэгчийн сертификат, холбогдох олон улсын стандартад нийцсэн тохирлын гэрчилгээ, ашиглалтын заавар, зураг, каталоги** зэргийг заавал ирүүлнэ.
5. Мөн тухайн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн өөрийн гаргасан чанарын хяналтын стандартуудад тодорхойлогдсон бүх хяналт хэмжилт, туршилтын протоколыг хавсаргасан байх.
6. ГОСТ 15150-69 “Машин, багаж хэрэгсэл болон бусад техник эд зүйлс. Цаг уурын янз бүрийн бүсэд зориулсан хийцүүд. Гадаад орчны цаг уурын нөлөөллийн хүчин зүйлээр ангилагдсан ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлийн ангилал” стандартад тодорхойлогдсон ангилалын дагуу У1 нөхцөлд суурилуулж ашиглагдахаар байх ёстой. Орчны төрөл нь дээрх стандартын ангиллаар II төрөл буюу “үйлдвэрлэлийн” байх ёстой.
7. Нийлүүлэгдэх трансформаторууд нь доорх техникийн үзүүлэлтүүдтэй байна. Үүнд:
 - а. Гурван фазын 2 ороомогтой, энгийн тосон болон энгийн агааран хөргөлттэй, битүүмжилсэн хийцтэй тосон трансформатор байна.

- b. Ачаалалгүй үед хүчдэл тохируулагчтай байх ба 5 тавилтай / $\pm 2 \times 2.5\%$ / байна.
- c. Ашиглалтын хугацаа 25 жилээс доошгүй байна.
- d. Трансформаторын техникийн өгөгдөл:

Чадал, кВА	Тип марк	Холболтын бүлэг	Хэвийн хүчдэл, кВ		Алдагдал, кВт /ихгүй/		Хоосон явалтын алдагдал, %	БЗ-ны үеийн хүчдэл, %
			ӨХ	НХ	Хоосон явалт	Богино залгаа		
400	S-11M	Д/Үн-11	10.5 6.3	0.4	0.57-с ихгүй	4.3-аас ихгүй	1.0-аас ихгүй	4.0-өөс ихгүй
1000	ТМГ	Д/Үн-11	10.5	0.4	1.4-с ихгүй	10.8-с ихгүй	0.8-аас ихгүй	5.5-аас ихгүй

ШАЛГАЛТ ТУРШИЛТ:

Нийлүүлэгдэх бараанд хийгдсэн байх үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох тайлангийн хамт ирүүлэх шаардлагатай. Эдгээр туршилтуудад дараах зүйлүүд хамрагдана. Үүнд:

- Халалтын туршилт
- Трансформаторын их биеийн механик даацын туршилт
- Трансформаторын их биеийн битүүмжлэлийн туршилт
- Тусгаарлагын цахилгаан даацын туршилт
- Богино залгааны даацын туршилт
- Акустик туршилт
- Трансформаторын тосны туршилт
- Идэвхитэй хэсгүүд дэх механик даацын туршилт
- Мөн эдгээрээс гадна ороомгийн холболтын бүлэг, хоосон явалтын алдагдал, богино залгааны алдагдал зэргийг шалгасан байна.

Мөн трансформаторуудыг нийлүүлэхийн өмнө хэвийн чадалдаа хүрч байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан байх шаардлагатай.

ТЭЭВЭРЛЭЛТ БА БАГЛАА БООДОЛ:

Трансформаторыг тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах, ашиглалтанд оруулах бүх ажлыг үйлдвэрлэсэн газрын техникийн паспорт, заавар журамд нийцүүлэн гүйцэтгэх ёстой.

Баглаа боодлыг тодорхойлолтын ерөнхий шаардлагын дагуу хийнэ. Үйлдвэрлэлээс гаргахаас өмнө трансформатор бүрийг хатаах ба тос эсвэл хийгээр дүүргэсэн байна.

Трансформатор бүрийг бүрэн бүтэн зөөвөрлөх ба салж болох дагалдах жижиг хэсгүүдийг аюулгүй баглан трансформаторт хавсаргана. Трансформаторын угсралтын болон ашиглалтын үеийн засвар үйлчилгээ хийх зааварчилгааг трансформаторт бүрэн хавсаргасан байх ёстой.

САНАМЖ

Дээрх техникийн тодорхойлолт нь тухайн материал, тоноглолын ерөнхий шаардлага бөгөөд тендерийн үнэлгээний хороо тухайн тоноглолын захиалсан тоо ширхэг, зориулалт, төрөл зэргээс хамааруулан нягталж ашиглах шаардлагатай.

! Тендер зарлахдаа уг хэсгийг хасаж ашиглана уу.

ТЕХНИКИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭС